МЭДЭЭ · 2022 оны 10-р сарын 18

ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ БҮРТГЭЛТИЙН АЖИЛЛАГАА ХУУЛИЙН ХҮРЭЭНД ЯВАГДАЖ БАЙГАА ЭСЭХИЙГ ШАЛГАЖЭЭ



Баянгол дүүргийн прокурорын газраас тус дүүргийн Цагдаагийн газрын нэг, хоёрдугаар хэлтсийн зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах болон эрх бүхий албан тушаатнуудтай хамтарсан зөвлөгөөн зохион байгуулж, тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцлээ.

Тодруулбал, эрх бүхий албан тушаалтны явуулсан зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэхийг шалгасан шалгалтын дүнг танилцуулж, цаашид холбогдох хууль тогтоомж, журам зааврыг нэг мөр хэрэгжүүлж ажиллахыг анхааруулсан байна.





Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1978